АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК

Санхүүгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31
(Хараат бус аудиторын дүгнэлтийн хамт)

АГУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ 3
УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ 4
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 5
ТУСДАА САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН 7
ТУСДАА АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН 8
ТУСДАА ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН 9
ТУСДАА МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН 10
1. Компанийн ерөнхий мэдээлэл 11
2. Компанийн үйл ажиллагааны орчин 11
3. Тайлан бэлтгэх үндэслэл 11
4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд 14
5. Шинэ ба нэмэлт өөрчлөлт орсон стандартууд болон тайлбаруудын хэрэгжилт . 22
6. Шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн мэдэгдлүүд 22
7. Үндсэн хөрөнгө 24
8. Биет бус хөрөнгө 25
9. Ашиглах эрхтэй хөрөнгө 26
10. Урт хугацаат хөрөнгө оруулалт 26
11. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 28
12. Дансны болон бусад авлага 28
13. Бараа материал 29
14. Урьдчилж төлсөн тооцоо 29
15. Бусад санхүүгийн хөрөнгө 29
16. Дансны болон бусад өр төлбөр 29
17. Богино болон урт хугацаат зээл 29
18. Урьдчилж орсон орлого 30
19. Богино хугацаат бондын өр төлбөр 30
20. Хойшлогдсон татварын өр төлбөр 30
21. Бусад нөөц өр төлбөр 31
22. Эздийн өмч 31
23. Орлого 31
24. Ногдол ашгийн орлого 32
25. Борлуулалт, маркетингийн зардал 32
26. Ерөнхий ба удирдлагын зардал 32
27. Бусад орлого, зардал 33
28. Санхүүгийн зардал 33
29. Гадаад валютын ханшийн зөрүүний олз/(гарз) 33
30. Виртуал хөрөнгийн үнэлгээнээс үүссэн олз/(гарз) 33
31. Бусад олз/(гарз) 34
32. Орлогын албан татварын зардал/(нөхөлт) 34
33. Холбоотой талууд 34
34. Санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл 37
35. Бодит үнэ цэний хэмжилт 39
36. Капиталын удирдлагын бодлого, журам 41
37. Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага 42
38. Тайлагналын өдрийн дараах үйл явдал 42
39. Тайлангийн орчуулга 42

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төлөөлөн удирдах зөвлөл:	Дарга	Ч.Ганхуяг
	Гишүүн	Бруно Рашле
	Гишүүн	А.Сүхдорж
	Гишүүн	О.Одбаяр
	Гишүүн	Б.Золбоо
	Хараат бус гишүүн	Арно Вентура
	Хараат бус гишүүн	М.Сэргэлэн
	Хараат бус гишүүн	Михаил Зелдович
	Хараат бус гишүүн	Роланд Нэш
Удирдлагын баг:	Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Г.Уянга
	Группын Санхүү Эрхэлсэн Захирал	Г.Билгүүн
	Хөрөнгө Оруулалтын Зөвлөх	А.Азбаяр
	Группын Хөрөнгө Оруулалт Эрхэлсэн	Х.Билгүн
	Дижитал Шилжилт Эрхэлсэн Захирал	Б.Баттулга
	Дата Судалгаа Эрхэлсэн Захирал	Ч.Алтан-Өлзий
	Мэдээллийн Технологи Эрхэлсэн Захирал	Х.Ууганбаяр
	Аудит Эрхэлсэн Захирал	М.Мөнх-Эрдэнэ
	уулийн Ахлах Зөвлөх	Ө.Ашхүү
	Олон Нийтийн Харилцаа Эрхэлсэн Захирал	Б.Ганчимэг
	Креатив Стратеги Эрхэлсэн Захирал	Х.Энхбаяр
	Ахлах нягтлан бодогч	Б.Баасансүрэн
Албан хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Чингисийн талбай-2, Сентрал Таур, 17 давхар	
Харилцагч банк:	Голомт Банк ХК Худалдаа хөгжлийн банк ХК ХААН банк ХК ХАС банк ХК Богд банк ХХК Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв	
Аудитор:	Нексиа Глобал Монголиа Аудит ХХК Мэргэшсэн нягтлан бодогчид	

Ard Санхүүгийн Нэгдэл

Утас: 7700 3322
И-мэйл хаяг: info@ardholdings.com

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8-р хороо, Сүхбаатарын талбай-2,
Сэнтрал Тауэр, 17 давхар

2026 он 4 сар 28 өдөр

№ 26/49

УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

Энэхүү тайлангийн 5-6 дах хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй уншигдах дараах мэдэгдэл нь Ард Санхүүгийн Нэгдэл Хувьцаат Компанийн (цаашид 'Компани' гэх) 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандарт ('СТОУС')-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлага ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ('СТОУС'), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Компанийн 2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг шалгахыг зөвшөөрч байна.

Г.Уянга
Гүйцэтгэх захиралын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Баасансүрэн
Ахлах нягтлан бодогч

Монгол Улс, Улаанбаатар хот
2026 оны 04 сарын 28

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Ард Санхүүгийн Нэгдэл ХК–ийн Хувьцаа эзэмшигчид

Аудиторын дүгнэлт

Бид "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК (цаашид "Компани" гэх)–ийн 2025 оны 12 дугаар сарын 31–ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")–ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")–уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"–ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангуудын (үүнд тодруулгууд багтана) ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"–ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Баталсан

Э. Булган
Партнер

Монгол Улс, Улаанбаатар хот
2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН

ТУСДАА САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Тод	2025-12-31	2024-12-31
Хөрөнгө			
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	7	258,068	260,295
Биет бус хөрөнгө	8	6,476,409	500,764
Ашиглах эрхтэй хөрөнгө	9	838,212	4,161,784
Урт хугацаат хөрөнгө оруулалт	10	49,169,436	51,612,805
Бусад эргэлтийн бус хөрөнгө		-	576
Нийт эргэлтийн бус хөрөнгө		**56,742,125**	**56,536,224**
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	11	7,581	5,202
Дансны болон бусад авлага	12	61,025,046	51,981,471
Бараа материал	13	85,467	111,794
Урьдчилж төлсөн тооцоо	14	1,523,245	1,867,500
Бусад санхүүгийн хөрөнгө	15	277,424	248,724
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө		-	4,095,647
Нийт эргэлтийн хөрөнгө		**62,918,763**	**58,310,338**
НИЙТ ХӨРӨНГӨ		**119,660,888**	**114,846,562**
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны болон бусад өр төлбөр	16	39,334,019	32,120,066
Богино хугацаат зээл	17	6,024,244	5,866,254
Урьдчилж олсон орлого	18	7,396,988	7,525,707
Богино хугацаат хаалттай бондын өр төлбөр	19	3,520,000	370,000
Богино хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	9	392,493	1,319,671
Нийт богино хугацаат өр төлбөр		**56,667,744**	**47,201,698**
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	17	9,611,853	8,852,663
Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	9	437,134	2,963,093
Хойшлогдсон татварын өр төлбөр	20	367,955	1,207,756
Бусад нөөц өр төлбөр	21	1,057,971	-
Нийт урт хугацаат өр төлбөр		**11,474,913**	**13,023,512**
Нийт өр төлбөр		**68,142,657**	**60,225,210**
Эздийн өмч	22		
Хувийн өмч	22.1	28,614,263	28,614,263
Нэмж төлөгдсөн капитал	22.1	492,181	2,927,696
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	22.2	3,789,108	1,803,519
Эздийн өмчийн бусад хэсэг	22.2	13,799	13,799
Хуримтлагдсан ашиг	22.3	18,608,881	21,262,075
Нийт эздийн өмч		**51,518,232**	**54,621,352**
Нийт өр төлбөр болон эздийн өмч		**119,660,888**	**114,846,562**

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН

ТУСДАА АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Тод	2025	2024
Менежментийн үйлчилгээний орлого	23	3,596,651	3,513,280
Ногдол ашгийн орлого	24	8,071	871,915
Хөрөнгө оруулалтын борлуулалтаас үүссэн олз		311,862	5,590,160
Нийт орлого		**3,916,584**	**9,975,355**
Борлуулалт, маркетингийн зардал	25	(128,154)	(685,751)
Ерөнхий ба удирдлагын зардал	26	(5,204,979)	(5,517,215)
Бусад зардал	27	(158,908)	(351,230)
Үйл ажиллагааны ашиг/алдагдал		**(1,575,457)**	**3,421,159**
Санхүүгийн зардал	28	(3,495,974)	(3,105,296)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	29	(406,557)	(67,135)
Виртуал хөрөнгийн үнэлгээнээс үүссэн олз (гарз)	30	6,306,780	(412,132)
Бусад олз (гарз)	31	145,502	
Татвар төлөхийн өмнөх алдагдал (ашиг)		**974,294**	**(163,404)**
Орлогын татварын зардал (нөхөлт)	32	21,540	255,926
Тайлант үеийн цэвэр алдагдал (ашиг)		**995,834**	**92,522**
Бусад дэлгэрэнгүй орлого			
Виртуал хөрөнгийн бодит үнэ цэний өөрчлөлт		1,985,588	(29,819,473)
Бусад дэлгэрэнгүй орлогын дүн		**2,981,422**	**(29,726,951)**
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		**0.10**	**(1.04)**

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ

ТУСДАА ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**28,614,263**	**2,927,696**	**28,362,014**	**13,799**	**24,344,457**	**84,262,229**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт ба алдааны залруулга	-	-	-	-	86,074	86,074
Залруулсан үлдэгдэл	**28,614,263**	**2,927,696**	**28,362,014**	**13,799**	**24,430,531**	**84,348,303**
Тайлант жилийн ашиг	-		-	-	92,522	92,522
Хөрөнгийн бодит үнэ цэний өөрчлөлт	-		(29,819,473)	-	-	(29,819,473)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-		3,260,978	-	(3,260,978)	-
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**28,614,263**	**2,927,696**	**1,803,519**	**13,799**	**21,262,075**	**54,621,352**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт ба алдааны залруулга	-		-	-	25,512	25,512
Залруулсан үлдэгдэл	**28,614,263**	**2,927,696**	**1,803,519**	**13,799**	**21,287,587**	**54,646,864**
Тайлант жилийн ашиг	-	(2,435,515)			995,834	(1,439,681)
Хөрөнгийн бодит үнэ цэний өөрчлөлт	-	-	2,735,714	-	-	2,735,714
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	(750,125)	-	(3,674,540)	(4,424,665)
2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**28,614,263**	**492,181**	**3,789,108**	**13,799**	**18,608,881**	**51,518,232**

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН

ТУСДАА МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Тод	2025	2024
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн		**3,380,343**	**2,344,641**
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		3,380,343	2,344,961
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		-	75
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		-	605
Мөнгө зарлагын дүн		**8,976,165**	**7,034,217**
Ажиллагчдад төлсөн		773,095	1,309,585
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		225,000	294,556
Бараа материал худалдан авахад төлсөн		78,924	-
Ашиглалтын зардалд төлсөн		145,021	39,649
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		60,651	96,069
Хүүний төлбөрт төлсөн		3,674,288	1,070,007
Татварын байгууллагад төлсөн		780,223	100,604
Даатгалын төлбөрт төлсөн		16,724	16,554
Бусад мөнгөн зарлага		3,222,239	4,377,191
Үндсэн үйл ажиллагааны ашиг/(алдагдал)		**(5,595,822)**	**(4,689,574)**
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн		**18,537,247**	**39,672,400**
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		522,959	56,337
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		17,406,041	39,557,503
Хүлээн авсан хүүгийн орлого		600,176	6,772
Хүлээн авсан ногдол ашиг		8,071	51,788
Мөнгөн зарлагын дүн		**12,218,433**	**40,352,900**
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		271,000	42,541
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		11,947,433	18,389,702
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		-	21,920,657
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**6,318,814**	**(680,500)**
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн		**5,147,948**	**14,648,028**
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		5,147,948	14,648,028
Мөнгөн зарлагын дүн		**5,868,560**	**9,601,554**
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		5,868,560	9,601,554
Төлсөн ногдол ашиг		-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**(720,612)**	**5,046,474**
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/ (бууралт)		**2,380**	**(323,600)**
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		**5,202**	**328,802**
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		**7,581**	**5,202**

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

1. Компанийн ерөнхий мэдээлэл

Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид "Компани" гэх) нь 2005 үүсгэн байгуулагдсан ба компанийн оноосон нэр нь “И Ай Ти” ХХК байсан бөгөөд 2014 оны 04-р сарын 08-ны өдрийн ТУЗ-ын шийдвэрээр одоогийн нэрээр өөрчилж 2014 оны 06-р сарын 26-ны өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлсэн. 2001861 тоот регистр бүхий 9010001145 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээг авсан. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2014 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн шийдвэрийн дагуу хаалттай хувьцаат компани болох ажлыг зохион байгуулж 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр эрх бүхий байгууллагын зөвшөөрөл гарснаар улсын бүртгэлд бүртгүүлсэн.

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь:

1. Хөрөнгө оруулалт
2. Бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

2. Компанийн үйл ажиллагааны орчин

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбарт тулгуурласан хэвээр байгаа бөгөөд нүүрс, зэсийн экспорт эдийн засагт голлох нөлөө үзүүлж байна. Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2025 онд ойролцоогоор 6.0% - 6.3% орчим байсан бөгөөд энэхүү өсөлтийг улсын хэмжээнд зэсийн үйлдвэрлэл нэмэгдсэн болон хөдөө аж ахуйн салбарын эргэн сэргэлттэй холбон тайлбарлаж болохоор байна. Дунд хугацааны эдийн засгийн өсөлтийн төлөвийг ерөнхийд нь тогтвортой гэж үнэлж байгаа боловч дэлхийн худалдааны бодлогын өөрчлөлтөөс үүдэлтэй шууд бус нөлөөлөл зэрэг тодорхой эрсдэл, тодорхойгүй байдал 2025 ондоо үргэлжилсэн болно.

ОХУ болон Украины дайн нь олон улсын худалдаа, эрчим хүчний зах зээлд нөлөөлсөөр байгаа бол Израиль-Газын мөргөлдөөн нь дэлхийн эдийн засагт, ялангуяа газрын тосны үнэд тодорхойгүй байдлыг бий болгож байна. Эдгээр хүчин зүйлс нь Монгол Улсын инфляц, санхүүгийн зах зээл, эдийн засгийн ерөнхий төлөвт нөлөөлж болзошгүй.

Байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) асуудал бизнесийн орчинд улам бүр чухал байр суурь эзлэх боллоо. Монгол Улс эдийн засгийн олон талт хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд 2030 он гэхэд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30%-д хүргэх зорилт тавьж байгаа бөгөөд уул уурхайн салбарын компаниудад ил тод, тогтвортой үйл ажиллагаа явуулах шаардлага нэмэгдэж байна. Олон улсын хөрөнгө оруулагчдын хүлээлт, зохицуулалтын шинэ шаардлагуудын хүрээнд ESG-тэй уялдсан бизнесийн загварыг хэрэгжүүлэх нь зайлшгүй болж байна.

Удирдлага нь Компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, ажилчдаа дэмжих чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч байна. Гэсэн хэдий ч өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлын ирээдүйн үр нөлөөг урьдчилан таамаглахад хэцүү бөгөөд удирдлагын одоогийн хүлээлт, тооцоолол нь бодит үр дүнгээс ялгаатай байж болно.

3. Тайлан бэлтгэх үндэслэл

3.1 Ерөнхий зарчмууд

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуйг нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын гол товчоо хэсэгт толилуулсан. Өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд уг бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үеүдэд тууштай баримталж мөрдөх болно.

Компанийн нягтлан бодох бүртгэлийн болон тайлагнагч валют нь Монгол улсын мөнгөн тэмдэгт болох Төгрөг юм.

Эдгээр санхүүгийн тайлангууд нь төгрөгөөр илэрхийлэгдэж, мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

НЭКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

3. Тайлан бэлтгэх үндэслэл (үргэлжлэл)

3.1 Ерөнхий зарчмууд (үргэлжлэл)

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС') болон тайлбарууд (хамтад нь СТОУС гэх)-ын дагуу бэлтгэсэн.

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд тодорхой, чухал нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийхийг шаарддаг. Мөн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд удирдлагаас шийдэл гаргахыг шаарддаг. Санхүүгийн тайлан бэлтгэхэд хийгдсэн нөлөө бүхий шийдэл ба тооцоолол болон түүний нөлөөллийн талаар нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэлд нэмж тодруулсан.

3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж

Компани нь эдгээр санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөх дүнд болон дараагийн санхүүгийн жилийн хөрөнгө, өр төлбөрийн дансны дүнд нөлөөлөх тооцоолол болон таамаглалыг хийдэг. Удирдлагын туршлага болон ирээдүйн үйл явдлын талаарх тухайн нөхцөл байдалд зохистой гэж үзсэн хүлээлт зэрэг бусад хүчин зүйлүүдэд үндэслэдэг чухал тооцоолол дүгнэлтүүд нь байнга дахин хянагдаж байдаг. Удирдлага мөн нягтлан бодох бүртгэлийн бодлогоо хэрэглэхдээ тооцооллоос гадна тодорхой дүгнэлтийг хийдэг. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд хамгийн мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үнэлэлтүүд болон дараагийн санхүүгийн жилийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнгүүдэд мэдэгдэхүйц тохируулга хийх шаардлага үүсгэж болох тооцооллуудад дараах зүйлс хамаарна.

Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилт. ХБЭА-ын хэмжилт нь арга зүй, загвар, мэдээллийн өгөгдлүүдийг тодорхойлох зэргийг багтаасан чухал тооцоолол байна.

Эрсдэлийн алдагдлын хасагдуулгад дараах бүрэлдэхүүн үзүүлэлтүүд чухал нөлөөтэй: төлбөр төлөгдөхгүй байх тодорхойлолт, зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (SICR), төлбөр төлөгдөхгүй байх магадлал (PD), төлөгдөөгүй үлдсэн үлдэгдэл (EAD), төлбөр төлөгдөхгүй байх эрсдэлээс үүсэх алдагдал (LGD), мөн макро эдийн засгийн хувилбарын загвар.

Компани хорогдуулсан өртөг болон БДОБҮЦ-ээр ангилагдсан бүх өрийн хэрэглүүрүүдийн хувьд ХБЭА-ыг тооцоолдог бөгөөд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын тооцоолол болон бодит эрсдэлийн алдагдлын хоорондын зөрүүг багасгах загварууд болон түүнд ашиглагдах өгөгдлүүдийг байнга хянаж баталгаажуулдаг.

Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилт. Компани ХБЭА-ыг тооцоолох үедээ зэрэглэл тогтоох олон улсын үнэлгээний байгууллагуудын зээлжих зэрэглэлтийн үнэлгээнд үндэслэн хялбаршуулсан арга зүйг ашигладаг. Төлбөр төлөгдөхгүй байх магадлалын зэрэглэлийг тодорхойлох судалгаанд тулгуурлан харилцагч талын зээлжих зэрэглэлийн үнэлгээнд ирээдүйд чиглэсэн мэдээллийг оруулсан гэж удирдлага үзэж байгаа болно.

Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (“SICR"). Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг тодорхойлохын тулд Компани тайлант жилийн эцэст санхүүгийн хэрэглүүрийн бүх хугацаан дахь дефолт болох эрсдэл болон анх хүлээн зөвшөөрөх үеийн дефолт болох эрсдэлийг харьцуулна.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

3. Тайлан бэлтгэх үндэслэл (үргэлжлэл)

3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж (үргэлжлэл)

Үнэлгээгээр тайлант жилийн эцэст тодорхой нэг зээлийн эрсдэлийн түвшинд хүрэх гэхээсээ илүү зээлийн эрсдэлийн харьцангуй өсөлтийг нь авч үздэг. Компани бүхий л боломжит ашиглаж болохуйц бэлэн байгаа ирээдүйг харсан мэдээллийг хэт их зардал, хүчин чармайлт гаргалгүйгээр авч үздэг. Тодруулга 20-оос харна уу.

Бизнес загварын үнэлгээ. Бизнес загварт үндэслэн санхүүгийн хөрөнгийг ангилна. Удирдлага бизнес загварын үнэлгээг хийхдээ санхүүгийн хэрэглүүрүүдийн багц болон ижил байдлын түвшнийг тодорхойлохдоо үнэлэлт өгсөн. Борлуулалтын гүйлгээг үнэлэхдээ Компани нь түүхэн давтамж, цаг хугацаа болон үнэ цэнэ, борлуулалтын зорилго, ирээдүйн борлуулалтын үйл ажиллагааны тухай хүлээлт зэргийг авч үздэг. Хэрэв “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК (цаашид “Компани” гэх) бодит үнэ цэнээр илэрхийлэх сонголтыг ашиглан энэ ангилалд санхүүгийн хөрөнгийг ангилах шийдвэр гаргасан бол цаашид уг хөрөнгийн ангиллыг өөрчлөхгүй.

Санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилготой бизнесийн загвар нь санхүүгийн хөрөнгийг дуусвар хугацаа хүртэл эзэмших нөхцөлд тохиолддог. Компанийн хяналтаас гадуур нэг удаагийн үйл явдлын үр дүнд хийгдэж болох санхүүгийн хөрөнгийн борлуулалт нь байнга давтагддаггүй бөгөөд Компанийн зүгээс таамаглах боломжгүй байдаг. Мөн зээл чанаргүйдсэнээс үүсэн гарах боломжит алдагдлыг багасгах зорилготой борлуулалтын гүйлгээ болон зээлийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хамааралгүй бусад хугацаанаас өмнөх бага давтамжтай, үнийн дүн багатай борлуулалтын үед ч тухайн санхүүгийн хөрөнгө “Цуглуулах зорилготой бизнесийн загвар”-т нийцсэн хэвээр байж болох юм.

“Цуглуулах болон худалдан борлуулах зорилгоор эзэмших” бизнес загвар нь гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах болон тухайн хөрөнгийг борлуулснаас үүссэн мөнгөн урсгалыг цуглуулах нь мөн энэхүү бизнес загварын зорилгыг биелүүлэхэд чухал юм. Үүнд хөрвөх чадвартай байдлаа удирдахын тулд тодорхой нэг өгөөжид хүрэхийн тулд эсвэл тухайн хөрөнгийг санхүүжүүлэхэд ашигласан өр төлбөрийн хугацааг санхүүгийн хөрөнгийн хугацаатай нь тохируулахын тулд гэх мэт.

Мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй эсэх үнэлгээ (“ЗХҮТ”)

Санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлтөөс (“ЗХҮТ”) бүрдэж буй эсэхийг тодорхойлоход үнэлэлт өгөх шаардлагатай.

Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн элемент нь өөрчлөгдөх магадлалтай, жишээ нь хэрэв гэрээний хүүгийн түвшин давтамжтайгаар өөрчлөгддөг боловч тэр давтамж нь өрийн хэрэглүүрүүдийн суурь хүүгийн түвшний чиглэлтэй таарахгүй байдаг. Өөрчлөгдсөн мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн нөлөөг тодорхой хэрэглүүрийн мөнгөн урсгалыг ЗХҮТ мөнгөн урсгалтай жишиг өрийн хэрэглүүртэй харьцуулалт хийх байдлаар үнэлэх бөгөөд үүнийг тайлант хугацаа бүрд болон хэрэглүүрийн хугацааны туршид хуримтлуулан тооцно. Үнэлгээ хамгийн боломжит бүх тохиолдолд хийгдсэн бөгөөд санхүүгийн зах зээлд тохиолдол болох санхүүгийн стрессийн боломжит нөхцөл байдалд ч мөн хийгдсэн байна.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

3. Тайлан бэлтгэх үндэслэл (үргэлжлэл)

3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан гол тооцоолол ба үнэлэмж (үргэлжлэл)

Холбоотой талын ажил гүйлгээний анхны хүлээн зөвшөөрөлт

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад Компани холбогдох талуудтай ажил гүйлгээнд оролцдог. СТОУС 9 нь санхүүгийн хэрэглүүрийг тэдгээрийн бодит үнэ цэнд суурилан анхны хүлээн зөвшөөрөлтөөр бүртгэхийг шаарддаг. Энэхүү ажил гүйлгээг зах зээлийн эсвэл зах зээлийн бус (өөрөөр хэлбэл энэхүү ажил гүйлгээтэй холбоотой идэвхтэй зах зээл байхгүй) хүүтэй уялдсан эсэхийг тодорхойлоход үнэлгээ хийдэг. Энэхүү үнэлгээнд өөр бусад хамааралгүй этгээдтэй хийсэн ижил төрлийн ажил гүйлгээний үнийн дүн болон үр ашигт хүүгийн шинжилгээг ерөнхий зарчим болгодог. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний нөхцөл болон дансны үлдэгдлийг Тодруулга 7-д тусгасныг харна уу.

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Компанийн эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг дор толилуулав. Өөрөөр заагаагүй бол тус бодлогуудыг толилуулж буй бүх тайлант хугацаануудад тууштай мөрдөж хэрэгжүүлсэн болно.

4.1 Тасралтгүй байх зарчим

Удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчимд үндэслэн бэлтгэсэн. Компанийн санхүүгийн мэдээллийг ойрын ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн таамаглалд тулгуурлан бэлтгэсэн бөгөөд үйл ажиллагаагаа хэвийн явуулж байх хугацаанд хөрөнгө орлогоо бодитой хэрэгжүүлж, өр төлбөр, амлалтаа биелүүлэх боломжтой байх болно гэж үзсэн.

4.2 Гадаад валютын ханшийн хөрвүүлэлт

Эдгээр санхүүгийн тайлангууд Компанийн бүртгэлийн мөнгөн тэмдэгт болох Монгол Төгрөг (“ТӨГ")-өөр илэрхийлэгдсэн болно.

4.3 Ажил гүйлгээнүүд болон үлдэгдэл дүнгүүд

Гадаад валютаарх мөнгөөр солигдох хөрөнгө ба өр төлбөрүүдийг Компанийн бүртгэлийн валют руу тухайн тайлагналын эцсийн өдрийн Монголбанк (“МБ”)-ны албан ханшаар хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ болон гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөөрх хөрөнгө ба өр төлбөрийг Компанийн бүртгэлийн валют руу тайлан тэнцлийн өдрийн МБ-ны жилийн эцсийн албан ханш руу хөрвүүлснээс үүсэх гадаад валютын ханшийн олз, гарзыг орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөтэй холбоотой гадаад валютын ханшийн олз, гарзыг орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд "санхүүгийн орлого, зардал"-аар толилуулна. Бусад бүх гадаад валютын ханшийн олз, гарзыг орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд 'Гадаад валютын ханшийн олз/(гарз), цэвэр дүн”-ээр толилуулна.

Жилийн эцсийн ханшаарх хөрвүүлэлт нь түүхэн өртгөөр хэмжигддэг мөнгөн бус зүйлсэд хамаарахгүй. Гадаад валютаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн мөнгөн бус зүйлийг, түүний дотор өмчийн хөрөнгө оруулалтыг, бодит үнэ цэнийг нь тодорхойлсон өдрийн ханшийг ашиглан хөрвүүлдэг. Гадаад валютаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх мөнгөн бус зүйлс дэх валютын ханшийн өөрчлөлтийн нөлөөг бодит үнэ цэнийн олз эсвэл гарзын нэг хэсэг болгон бүртгэдэг.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.4 Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Элэгдэл, хорогдуулалт тооцдог хөрөнгийг өөрийн дансны үнээ нөхөх боломжгүйг илтгэж буй үйл явдал, нөхцөл байдлын өөрчлөлт бүрд түүний үнэ цэнийн бууралтыг хянаж үздэг. Үнэ цэнийн бууралтын гарзыг бүртгэхдээ тус хөрөнгийн дансны үнийн нөхөгдөх дүнгээс давсан дүнгээр хүлээн зөвшөөрнө. Нөхөгдөх дүн нь хөрөнгийн борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнэ болон ашиглалтын үнэ цэнийн аль их нь байна. Үнэ цэнийн бууралтыг үнэлэхийн тулд хөрөнгийг түүний бие даасан бэлэн мөнгөний урсгалд (мөнгө бий болгогч нэгж) хамгийн бага тодорхойлж болохуйц үнийн түвшинд нэгтгэдэг.

4.5 Санхүүгийн хэрэглүүр - хэмжилтийн үндсэн нөхцөл

Санхүүгийн хэрэглүүрүүдийг ангиллаас хамааран дараах байдлаар бодит үнэ цэнээр эсвэл хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

Бодит үнэ цэнэ гэж хэмжилт хийгдэх тухайн өдөр зах зээлд оролцогч талуудын хооронд хөрөнгө худалдсан бол хүлээн авах буюу өр төлбөр шилжүүлсэн бол төлөх байсан үнийг хэлнэ. Бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо бол идэвхитэй зах зээл дээрх үнэ байдаг. Идэвхтэй зах зээл гэдэг нь давтамж, тоо хэмжээний хувьд үнийн мэдээллийг тогтмол нийлүүлж чадах хөрөнгө, өр төлбөртэй холбоотой гүйлгээ гарч байдаг зах зээлийг хэлдэг. Идэвхитэй зах зээл дээр арилжаалагдаж байгаа санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хөрөнгө буюу өр төлбөр тус бүрийн жишиг үнэ болон аж ахуйн нэгжийн эзэмшиж буй хэрэглүүрүүдийн тоо хэмжээгээр хэмждэг.

Зах зээлийн өдөр тутмын хэвийн арилжааны хэмжээ нь сангийн эзэмшиж байгаа тоо хэмжээтэй харьцуулахад хангалтгүй байх мөн нэг арилжаагаар борлуулах захиалгын тоо хэмжээ зэрэг нь жишиг үнэнд нөлөөлөх тохиолдол байдаг.

Гүйлгээний зардал нь санхүүгийн хэрэглүүрийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал нь гүйлгээ хийгдээгүй тохиолдолд гарахгүй байх байсан зардлыг хэлнэ. Гүйлгээний зардалд зуучлагч (мөн борлуулалтын агентын үүрэг гүйцэтгэж буй ажиллагсад), зөвлөхүүд, брокерууд болон дилерүүдэд төлсөн шимтгэл, хураамж, зохицуулах байгууллага, хөрөнгийн зах зээлийн байгууллагад төлсөн төлбөр, шилжүүлгийн татвар, хураамж хамаарна. Гүйлгээний зардалд өрийн шимтгэл эсвэл хөнгөлөлт, санхүүжилтийн зардал, захиргааны дотоод зардал, хадгалалтын зардал орохгүй.

Хорогдуулсан өртөг нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн дүнгийн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлогдсон гүйлгээний зардлын хорогдуулалт, мөн үнийн аливаа нэмэгдэл буюу хөнгөлөлтийн дүнгийн үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт орно. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн дискаунтчилсан нэмэгдэл буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй ба тэдгээрийг санхүүгийн байдлын тайлангийн холбогдох хэсэгт дансны үнээр тусгана.

Үр ашигт хүүгийн арга нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны туршид бүртгэлийн дүнгээс тооцогдох хүүгийн хувь (үр ашигт хүү)-ийг тогтмол байлгахаар хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид дискаунтчилж, санхүүгийн хэрэглүүрийн бүртгэлийн нийт дүнг гаргаж авах хүүгийн хувь болно.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.5 Санхүүгийн хэрэглүүр - хэмжилтийн үндсэн нөхцөл (үргэлжлэл)

Үр ашигт хүүгийн хувь нь хувьсах хүүтэй хэрэглүүрийн мөнгөн урсгалын хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл дискаунтчлах боловч хэрэглүүрт тусгагдсан хөвөгч хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн урамшуулал болон хөнгөлөлтийг, мөн зах зээлийн түвшинд тохируулагддаггүй ба бусад хувьсах хүчин зүйлсэд үл хамаарна. Эдгээр урамшуулал болон хөнгөлөлтийг хэрэглүүрүүдийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулна.

Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд гэрээний талуудын хооронд төлөх эсвэл хүлээн авах бүх хураамжийг оруулах ба тэдгээр нь үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болно. Худалдан авахад эсвэл шинээр олгоход үнэ цэнийн бууралт хийгдсэн зээл ("POCI") -ийг анх хүлээн зөвшөөрөх үед үр ашигт хүүний түвшинг зээлийн эрсдэлд тохируулахыг хэлнэ. Үүнд: анх хүлээн зөвшөөрөхдөө гэрээний төлбөрийн оронд хүлээгдэж буй мөнгөн гүйлгээнд үндэслэн тооцоолно.

4.6 Санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан хүлээн зөвшөөрөх

Санхүүгийн хэрэглүүрүүд нь анхлан гүйлгээний зардлыг тохируулсан бодит үнэ цэнээр бүртгэгддэг. Анхлан хүлээн зөвшөөрөх бодит үнэ цэнэ нь гүйлгээний дүнгээр хамгийн сайн нотлогдоно. Анхлан хүлээн зөвшөөрөх үед үүсэх олз эсвэл гарз нь бодит үнэ цэнэ болон гүйлгээний дүнгийн хооронд зөрүү гарсан тохиолдолд л бүртгэгдэх бөгөөд үүнийг зөвхөн ижил төрлийн хэрэглүүрийн идэвхтэй зах зээл дээрх сүүлийн үеийн арилжааны мэдээллээр баталгаажуулсан эсвэл зөвхөн идэвхтэй зах зээлээс авсан мэдээлэлд үндэслэж хийсэн үнэлгээний аргачлалаар тооцсон тохиолдлуудад бүртгэх болно. Анхлан хүлээн зөвшөөрсний дараа ХБЭА-ын нөөц сан нь хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгүүдийг хүлээн зөвшөөрдөг ба өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтуудыг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжиж гарсан үр дүн нь шууд бүртгэлийн гарз болдог.

Зохицуулах байгууллагаас тогтоосон эсвэл зах зээлийн жишгээр тогтсон (“хэвийн” борлуулалт болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан нийлүүлэх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л борлуулалт болон худалдан авалтыг арилжаа хийсэн өдөр буюу Компани тухайн санхүүгийн хөрөнгийг нийлүүлэх үүрэг хүлээсэн үед бүртгэнэ. Бусад бүх худалдан авалтыг Компани санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

4.7 Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт- хэмжилтийн төрөл

Компани нь санхүүгийн хөрөнгүүдийг дараах хэмжилтийн төрлүүдээр ангилна: Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ (“ААБҮЦ”), Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ (“БДОБҮЦ") болон Хорогдуулсан өртөг (“ХӨ"). Санхүүгийн өрийн хэрэглүүрийн ангилал болон дараа үеийн хэмжилт нь (i) холбогдох хөрөнгүүдийн багцыг удирдах Компанийн бизнес загвар (ii) хөрөнгийн мөнгөн урсгалын онцлогоос хамаарна.

4.8 Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт- бизнес загвар

Бизнес загвар нь Компанийн хөрөнгийг мөнгөн урсгал бий болгох зорилгоор хэрхэн удирдаж байгаагаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл Компанийн зорилго нь:

- Зөвхөн хөрөнгийн гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах (гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмших),
- Хөрөнгийн гэрээт мөнгөн урсгалыг цуглуулж авахаас болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авахын аль нь вэ гэдгээс хамаарах (гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах ба худалдах зорилгоор эзэмших),

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.8 Санхүүгийн хөрөнгө – ангилал болон дараа үеийн хэмжилт – Бизнес загвар (үргэлжлэл)

- Хэрэв 1 ба 2-ын аль ч тохиолдол биш бол санхүүгийн хөрөнгийг нь "бусад" гэсэн бизнес загварт хамааруулан ангилах ба ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжинэ.

Бизнес загварыг үнэлгээ хийсэн өдрийн байдлаар бэлэн байгаа багцын хувьд тодорхойлсон зорилгод хүрэхийн тулд Компанийн гүйцэтгэж буй үйл ажиллагаануудад хамааралтай бүхий л нотолгоонд үндэслэн хөрөнгүүдийн (багцын түвшинд) хувьд тодорхойлно. Бизнес загварыг тодорхойлоход Компанийн авч үзсэн хүчин зүйлүүдэд багцын бүрэлдэхүүн болон зорилго, холбогдох хөрөнгүүдийн мөнгөн урсгал хэрхэн цуглуулагдаж байсан талаарх өнгөрсөн үеийн туршлага зэргийг авч үздэг.

4.9 Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - мөнгөн урсгалын онцлог

Бизнес загвар нь хөрөнгийн гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмших эсвэл хөрөнгийн гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авах зорилготой үед мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн болон хүүгийн төлбөр (ЗҮХТ)-өөс бүрдэж буй эсэхэд Компани үнэлгээ өгдөг. Тэдгээрийн мөнгөн урсгал нь ЗҮХТ-ийн онцлогтой нийцсэн эсэхийг тодорхойлоход нуугдмал деривативыг агуулсан санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь авч үзнэ. Энэ үнэлгээг хийхдээ Компани гэрээт мөнгөн урсгал нь зээлийн гэрээний үндсэн тохиролцоонд нийцтэй эсэх, ялангуяа хүү нь зээлийн эрсдэл, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон зээлийн бусад эрсдэл, ашгийн түвшинг багтаасан эсэхийг авч үздэг.

Гэрээний нөхцөлүүд нь эрсдэлтэй эсвэл зээлийн үндсэн нөхцөлтэй үл нийцэх өөрчлөлтийг харуулж байвал санхүүгийн хөрөнгө нь ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэж ангилагдана. ЗҮХТ-ийн үнэлгээ нь хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед хийгдэх бөгөөд дараа хийгдэхгүй.

4.10 Санхүүгийн хөрөнгө - дахин ангилал

Багцыг удирдаж байгаа бизнес загвар бүхэлдээ өөрчлөгдсөн бол санхүүгийн хэрэглүүрийг дахин ангилна. Дахин ангилал нь ирээдүйд нөлөө үзүүлэх бөгөөд бизнес загвар өөрчлөгдсөний дараах хамгийн эхний тайлант үеийн эхнээс хэрэгжинэ.

4.11 Санхүүгийн хөрөнгө – үл хүлээн зөвшөөрөлт

Компани санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг: (а) хөрөнгийн төлбөрийг авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) санхүүгийн хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн өгсөн эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн дамжуулан өгөх хэлцэлд оролцож:

- хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлсэн эсвэл
- хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлээгүй ч, өөртөө авч үлдээгүй буюу хяналтын эрхийг хадгалж үлдээгүй.

Холбогдох тал хөрөнгийн борлуулалтад нэмэлт хязгаарлалт хийхгүйгээр холбоогүй гуравдагч талд бүхэлд нь худалдах боломжгүй тохиолдолд хяналтын эрхийг хадгалж үлдсэн гэж үзнэ.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.12 Санхүүгийн хэрэглүүрүүдийг хооронд нь хаах

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр бүртгэх нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийн хаалт хийх эрх зүйн үндэслэл байгаа бөгөөд төлбөрийг цэвэр дүнгээр барагдуулах эсвэл хөрөнгийг худалдаж, нэгэн зэрэг өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө байгаа тохиолдолд л зөвшөөрөгдөнө. Энэхүү хооронд нь хаах эрх нь (а) ирээдүйд болох үйл явдлын болзошгүй төлбөр биш байх, (б) дараах тохиолдол бүрийг хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжтой байх ёстой. Үүнд:

i. бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед
ii. төлбөр төлөгдөхгүй болох үед
iii. төлбөрийн чадваргүй болж дампуурсан үед бий болдог.

4.13 Санхүүгийн хөрөнгийг данснаас хасах

Компанийн санхүүгийн хөрөнгийн нөхөн төлөгдөх үйл ажиллагаа дуусгавар болсон, дахин нөхөн сэргээх үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь данснаас хасдаг. Данснаас хасах нь үл хүлээн зөвшөөрөх үйл явдлыг илэрхийлнэ. Компани гэрээний дагуу төлөгдөх дүнг шаардан авах эрхтэй боловч буцаан олгох магадлал бага үед хууль сахиулах үйл ажиллагаа дуусаагүй зарим санхүүгийн хөрөнгүүдийг данснаас хасдаг.

4.14 Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт

Бизнес загвар болон мөнгөн гүйлгээний шинж чанарт үндэслэн, Компани өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртгөөр, ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр бүртгэж ангилдаг. Өрийн үнэт цаасыг гэрээнд заасан ЗХҮТ-ийн мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор болон нягтлан бодох бүртгэлийн зөрүүг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулахын тулд ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнийг нь сайн дураар хүлээн зөвшөөрөөгүй үед хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Өрийн үнэт цаасыг гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах болон худалдан борлуулах зорилгоор эзэмшдэг бөгөөд эдгээр мөнгөн гүйлгээ нь ЗХҮТ байх ба бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөөгүй бол бусад орлогоор хүлээн зөвшөөрөгдөх бодит үнэ цэнээр бүртгэнэ. Тухайн хөрөнгүүдийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцоолж ашиг, тооцоолсон үнэ цэний бууралтын хасагдуулгыг тухайн жилийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Дансны үнэ дэх бусад бүх өөрчлөлтүүдийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө. Өрийн үнэт цаасыг бүртгэлээс хасах үед бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогоос ашиг алдагдал руу дахин ангилдаг.

Хорогдуулсан өртөг болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх шалгуурыг хангаагүй тохиолдолд өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт нь ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдэнэ.

Компани нягтлан бодох бүртгэлийн олон янзын сууриар хүлээн зөвшөөрөгдсөн буюу хэмжигдсэн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн хоорондын нягтлан бодох бүртгэлийн зөрүүг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулахад анхны хүлээн зөвшөөрөлтөөр Компанийн ААБҮЦ-ээрх өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтыг дахин тодорхойлж болно.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.15 Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт

Үнэт цаас гаргагчийн хэтийн төлөвт өмчийн тодорхойлолтыг хангасан санхүүгийн хөрөнгө (жишээ нь, мөнгөөр төлөх гэрээний үүргийг агуулаагүй санхүүгийн хэрэглүүр ба гаргагчийн цэвэр хөрөнгөнд үлдэх хувь оролцоог нотлох баримт) нь Компанийн өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг илтгэнэ. Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт нь бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөхөөс бусад тохиолдолд бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар хэмжинэ. Компанийн бодлогоор хөрөнгө оруулалтын өгөөж бий болгохоос бусад стратегийн зорилгоор хөрөнгө оруулалтыг эзэмшдэг бол өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөнө гэж тодорхойлдог. Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх сонголтын үед, бодит үнэ цэний олз ба гарзыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, цаашид болон түүнийг борлуулсан үед ашиг, алдагдалд дахин ангилж бүртгэхгүй. Хэрэв үнэ цэний бууралтын гарз ба тэдгээрийн буцаалт байгаа тохиолдолд бодит үнэ цэний бусад өөрчлөлтөөс тусад нь хэмжихгүй. Компанийн төлбөр хүлээн авах эрх нь ийм хөрөнгө оруулалтын өгөөж гэхээсээ илүү хөрөнгө оруулалтын нөхөн төлбөрийг илэрхийлэхээс бусад тохиолдолд ногдол ашгийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

4.16 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд бэлэн мөнгө, банканд байршуулсан харилцах хадгаламжийн мөнгө, 3 сар болон түүнээс богино хугацаатай, хөрвөх чадвар сайтай бусад богино хугацаат хөрөнгө оруулалтыг хамааруулна. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг анх бодит үнэ цэнээр үнэлж, санхүүгийн тайланд хорогдуулсан өртгөөр толилуулна. Учир нь:

Компанитай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:

(i) тэдгээр нь гэрээний мөнгөн урсгалаас цуглуулагдан эзэмшиж байгаа болон тэдгээр мөнгөн гүйлгээ нь ЗҮХТ-ийг тусгасан байдаг болон

(ii) тэдгээр нь ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр тодорхойлогдоогүй байдаг.

4.17 Бусад авлага

Дансны ба бусад авлагуудыг анхлан бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба цаашдаа үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Авлагын хорогдуулсан өртөг гэж анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс эргэн төлөлт болон эрсдэлийн санг хассан цэвэр дүнг хэлнэ.

4.18 Бусад өглөг

Дансны болон бусад өглөгийг нөгөө тал гэрээнд заасан үүргээ биелүүлсэн үед хуримтлуулан бүртгэх ба анхлан бодит үнэ цэнээр, цаашид үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Нэгж эрхийг барагдуулахаар үүссэн өр төлбөрийг шилжүүлэн бүртгэсэн өдрийн цэвэр хөрөнгийн үнэлгээгээр өр төлбөрийг хэмжиж үнэлнэ.

4.19 Санхүүгийн өр төлбөр

Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Санхүүгийн өр төлбөрийг аль зохистой ангилалд нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх, зээл ба зээллэг, эсвэл үр нөлөөтэй хейджингийн хэрэглүүрээр анх хүлээн зөвшөөрнө. Бүх санхүүгийн өр төлбөрүүдийг анх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба зээл, зээллэг болон өр төлбөрийн хувьд шууд хамааралтай гүйлгээний зардлыг хассаны дараах дүнгээр хүлээн зөвшөөрнө. Компанийн санхүүгийн өр төлбөрт бусад өр төлбөр болон холбоотой талын өр төлбөр орно. Бүх санхүүгийн өр төлбөрийг зээл ба зээллэг гэж ангилдаг.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.19 Санхүүгийн өр төлбөр (үргэлжлэл)

Үл хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзэх ба бүртгэлийн дүнгийн зөрүүг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

4.20 Орлогын албан татвар

Орлогын албан татвар нь санхүүгийн тайланд тайлант хугацааны эцсийн байдлаар батлагдсан эсвэл үндсэндээ батлагдсан байгаа хууль тогтоомжийн дагуу хуримтлуулан бүртгэгдсэн байна. Орлогын албан татварын зардал нь тайлант хугацааны болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн буюу өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл шууд өмчид бүртгэгдсэнээс бусад тохиолдолд тухайн жилийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөнө.

Тайлант хугацааны албан татвар нь тухайн болон өмнөх тайлант хугацааны татвар ногдуулах ашиг эсвэл алдагдлаас бодогдсон татварын байгууллагад төлөх эсвэл буцаан авах дүн байна. Санхүүгийн тайланг холбогдох татварын тайланг тушаахаас өмнө баталгаажуулсан тохиолдолд татвар ногдуулах ашиг, алдагдлыг урьдчилсан тооцоонд үндэслэж тооцдог. Орлогын албан татвараас бусад татваруудыг үйл ажиллагааны зардалд бүртгэдэг.

Татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлэх үед хойшлогдсон орлогын албан татварыг тооцохдоо тайлан тэнцлийн өглөгийн аргыг ашиглах ба хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн тайлангийн зорилгоорх бүртгэлийн дүн болон татварын суурийн хоорондын түр зөрүүг тайлант хугацаанд тооцож бүртгэдэг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн чөлөөлтийн дагуу татвар ногдуулах ашиг болон бүртгэлийн ашгийн алинд нь ч нөлөөлдөггүй, мөн бизнесийн нэгдлээс бусад ажил гүйлгээнд хөрөнгө ба өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөх үед үүссэн түр зөрүүнд хойшлогдсон татвар бүртгэдэггүй. Хойшлогдсон татварын үлдэгдлийг тайлант хугацааны эцэст бүхэлдээ буюу үндсэндээ батлагдсан байсан татварын хувь хэмжээгээр тооцож байгаа бөгөөд түр зөрүү гарах хугацаанд буцаах эсвэл татварын алдагдлыг ирээдүйд ашиглагдах үед хэрэглэхээр хүлээгдэж байдаг.

Хасагдах түр зөрүү болон татварын алдагдал шилжүүлснээс үүссэн хойшлогдсон татварын хөрөнгийг ирээдүйд түр зөрүү буцах магадлалтай үед бүртгэх бөгөөд эдгээр түр зөрүүг ирээдүйд олох татварын ашгаас хасаж ашиглаж болохуйц хэмжээгээр л хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хаахдаа хуулиар хооронд нь хааж болох эрх үүссэн, тухайн хуулийн этгээд эсвэл цэвэр дүнгээр тооцох сонирхол бүхий хэд хэдэн хуулийн этгээдийн хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр болон орлогын албан татварыг хураан авах эрх бүхий татварын байгууллага нь ижил байгаа эсэхийг авч үзнэ.

4.21 Урьдчилж төлсөн тооцоо

Урьдчилгаа төлбөрийг өртгөөр нь буюу төлсөн мөнгөн дүнгээр үнэлж, бүртгэнэ. Урьдчилж төлсөн тооцоонд түр хугацаагаар байршуулсан барьцаа хөрөнгө, дэнчин болон бусдаас авах бараа, ажил, үйлчилгээний үнэнд төлсөн урьдчилгаа төлбөрийг бүртгэнэ. Үнэт цаасны арилжааны төлбөрийг хийснээр, барьцаа хөрөнгө болон дэнчинд тавьсан хөрөнгөө эргүүлэн авахад холбогдох урьдчилж төлсөн тооцооны дансыг кредитлэнэ.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.22 Цэвэр хөрөнгө

Гаргасан нэгж эрхийг эздийн өмчид тусгана. Компани нь нэгж эрхээ худалдахаар байнга санал болгож, эрэлтийн хэмжээгээр гаргадаг бөгөөд арилжааг өөрийн онлайн арилжааны системээр дамжуулан олон нийтэд чөлөөтэй арилжаална. Нэгж эрхээ арилжаалахдаа төлбөрийг дараа хийх нөхцөлөөр худалдах, эсвэл төлбөргүйгээр бусдад шилжүүлэхийг хориглох ба төлбөр хийгдсэний дараа нэгж эрхийг шилжүүлнэ. Компани нь гүйлгээнд гаргасан нэгж эрхээ буцааж худалдаж авах үүрэг хүлээх бөгөөд хөрөнгө оруулагч нэгж эрхээ буцаах захиалга өгөх тохиолдолд онлайн арилжааны системээр дамжуулан Компанид буцаан худалдана.

4.23 Ногдол ашиг

Компанийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахдаа Компанийн нэгж эрх эзэмшигчдийн эзэмшиж буй нэгж эрхийн тоонд суурилж харилцан адилгүй байна. Тайлант хугацааны эцэст хуримтлагдсан ашгийн данснаас Компанийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр тараах эсхүл Компанийн нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгөнд хуваарилах шийдвэрийг дүрэмд заасны дагуу ТУЗ гаргана. Компанийн хувьд үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасны дагуу Компанийн орлогоор ногдол ашиг хуваарилахгүй байж болно.

4.24 Болзошгүй өр төлбөрт зориулсан нөөц

Өр төлбөрийн нөөц гэж тодорхой төлөгдөх хугацаа болон үнийн дүнгүй санхүүгийн бус шинжтэй өр төлбөрийг хэлнэ. Компани урьд нь тохиолдсон үйл явдлын үр дүнд өнөөгийн (эрх зүйн эсвэл үүсмэл үүрэг хүлээсэн бөгөөд уг үүргийг биелүүлэхэд шаардагдах эдийн засгийн үнэ цэнэ бүхий эх үүсвэрийг гарган өгөх магадлалтай мөн уг үүргийн дүнг үндэслэлтэйгээр тооцоолох боломжтой тохиолдолд нөөц санг байгуулдаг. Тухайн үүрэгтэй холбоотой эрсдэлүүд болон мөнгөний цаг хугацааны үнэ цэнээр тооцсон өнөөгийн зах зээлийн үнэлгээг тусгасан татварын өмнөх хувиар тооцсон өглөгийг барагдуулахад шаардлагатай зарлагын өнөөгийн үнэ цэнийг хэмжиж нөөц санг байгуулдаг. Цаг хугацааны хүчин зүйлээс шалтгаалж өссөн нөөцийн хэмжээг хүүгийн зардлаар хүлээн зөвшөөрдөг.

4.25 Хүүгийн орлого

Хүүгийн орлогыг аккруэл суурьт үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ арга нь талууд хоорондын гэрээний дагуу хүлээн авсан бүх хураамж болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүгийн тооцоололд оруулан тооцож, хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого болгон бүртгэдэг. Үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болох хураамжид санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл санхүүгийн өр төлбөрийг үүсгэхэд шууд холбоотой.

Үүссэн болон худалдан авсан, эрсдэлийн үнэ цэнэ бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүгийн түвшин гэдэг нь хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг (үүнд анхны хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал орно) анх бодит үнэ цэнээр нь (худалдан авах үнээр илэрхийлэгддэг) хүлээн зөвшөөрөхдөө дискаунтчлах хүү юм. Үүний үр дүнд үр ашигт хүүгийн түвшин нь эрсдэлийн тохируулгатай байдаг.

Хүүгийн орлогыг доорхоос бусад тохиолдолд санхүүгийн хөрөнгийн дансны нийт үнээс үр ашигт хүүгийн түвшингээр тооцоолно:

- санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнийн бууралтанд орсон (3-р шатлал) бол хүүгийн орлогыг тооцохдоо хорогдуулсан өртгийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хасагдуулгыг хассан цэвэр дүнгээс үр ашигт хүүгийн түвшинг ашиглан тооцоолно,

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.25. Хүүгийн орлого (үргэлжлэл)

- худалдан авсан эсвэл анхны хүлээн зөвшөөрөлтөөр үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн хувьд тохируулагдсан үр ашигт хүүгийн түвшинг хорогдуулсан өртгөөр тооцоолно.

5. Шинэ ба нэмэлт өөрчлөлт орсон стандартууд болон тайлбаруудын хэрэгжилт

Дараах нэмэлт өөрчлөлт оруулсан стандартууд 2025 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон боловч Компанид мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй.

	Тайлбар	Гаргасан огноо	Мөрдөж эхлэх огноо
• НББОУС 21 Гол өөрчлөлт болон асуудлууд	*Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө* *Валют хөрвүүлэх боломжгүй байдлын талаарх нэмэлт, өөрчлөлтүүд:* Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь валютыг хөрвүүлэх боломжтой гэж үзэх нөхцөлийг тодорхойлж, валют хөрвүүлэх боломжгүй тохиолдолд хэрэглэгдэх валютын ханшийг тодорхойлох аргачлалын талаарх зааварчилгааг тусгасан болно.	2023 оны 8 дугаар сар	2025 оны 1 дүгээр сарын 1
• ТБНББСЗ стандарт Гол өөрчлөлт болон асуудлууд	*Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл* Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь ТБНББСЗ стандартууд дахь тухайн улс, харьяалалд хамаарах тодорхойлолт, зүй заалт зэргийг орлуулсан бөгөөд салбар нэгжүүд болон хэмжүүрүүдэд бодитой өөрчлөлт оруулаагүй болно.	2023 оны 12 дугаар сар	2025 оны 1 дүгээр сарын 1

Дээрх шинэ стандарт, стандартуудын өөрчлөлтүүд болон тайлбар нь Компанийн санхүүгийн байдал эсвэл гүйцэтгэлд томоохон нөлөө үзүүлээгүй болно.

6. Шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн мэдэгдлүүд

Компанийн санхүүгийн тайлангуудыг баталж гаргах өдрийн байдлаар батлагдаж гарсан ба хараахан хэрэгжиж эхлээгүй стандартууд болон тайлбаруудын жагсаалтыг дор үзүүлэв. Компани энэхүү стандартуудыг шаардлагатай тохиолдолд хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс мөрдөх хандлагатай байна.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

6. Шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн мэдэгдлүүд (үргэлжлэл)

СТОУС	Тайлбар	Гаргасан огноо	Мөрдөж эхлэх огноо
• СТОУС 7 ба СТОУС 9 Гол өөрчлөлт болон асуудлууд	*Санхүүгийн хэрэгсэл: Ангилал ба хэмжилт* Гол өөрчлөлт ба анхаарах асуудал: СТОУС 9 Санхүүгийн хэрэгслийн ангилал, хэмжилтийн шаардлагын хэрэгжилтийн дараах үнэлгээний үеэр тодорхойлогдсон асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн.	2024 оны 5 дугаар сар	2026 оны 1 дүгээр сарын 1
• Нягтлан бодох бүртгэлийн стандартын жилийн сайжруулалт • Гол өөрчлөлт болон асуудлууд	Дараах стандартуудад нэмэлт өөрчлөлт орсон: • СТОУС 1: Анх удаа хэрэгжүүлэгчийн хеджийн нягтлан бодох бүртгэл • СТОУС 7: Санхүүгийн хэрэгслийг данснаас хасах үед үүсэх ашиг, алдагдал • СТОУС 7: Шударга үнэ ба гүйлгээний үнийн хоорондын хойшлогдсон зөрүүний ил тод байдал • СТОУС 7: Танилцуулга ба зээлийн эрсдэлийн ил тод байдал • СТОУС 9: Түрээслэгчийн түрээсийн өр төлбөрийг данснаас хасах • СТОУС 9: Гүйлгээний үнэ • СТОУС 10: “Бодит агент”-ыг тодорхойлох • НББОУС 7: Зардлын арга	2024 оны 12 сар	2026 оны 1 дүгээр сарын 1
• СТОУС 18 • Гол өөрчлөлт болон асуудлууд	*Санхүүгийн тайлангийн танилцуулга ба ил тод байдал* Гол өөрчлөлт ба анхаарах асуудал: СТОУС 18 нь СТОУС хэрэглэж буй бүх аж ахуйн нэгжид хамаарах санхүүгийн тайлангийн мэдээллийг танилцуулах болон ил тод болгох шаардлагуудыг агуулна.	2024 оны 4 сар	2027 оны 1 дүгээр сарын 1
• СТОУС 19 • Гол өөрчлөлт болон асуудлууд	*Нийтийн хариуцлагагүй охин компаниуд: Ил тод байдал* Гол өөрчлөлт ба анхаарах асуудал: СТОУС 19 нь нийтийн хариуцлагагүй, шаардлага хангасан охин компаниуд бусад СТОУС стандартын оронд мөрдөж болох ил тод байдлын шаардлагуудыг тодорхойлсон.	2024 оны 5 сар	2027 оны 1 дүгээр сарын 1

Дээр дурдсанаас өөрөөр тайлбарлаагүй тохиолдолд шинэ стандарт болон өөрчлөлтүүд Сангийн санхүүгийн тайланд мэдэгдэхүйц их хэмжээний нөлөө үзүүлэхгүй гэж таамаглаж байна.

ЭКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

7. Үндсэн хөрөнгө

Мянган төгрөгөөр	**Тоног төхөөрөмж**	**Тээврийн хэрэгсэл**	**Тавилга, эд хогшил**	**Компьютер, дагалдах хэрэгсэл**	**Нийт**
Өртөг					
2024-01-01	**479**	**331,818**	**137,160**	**201,170**	**670,627**
Худалдаж авсан	-	-	8,206	29,945	38,151
Данснаас хассан	-	-	-	-	-
2024-12-31	**479**	**331,818**	**145,366**	**231,115**	**708,778**
Худалдаж авсан	-	246,364	377	-	246,741
Данснаас хассан	(479)	(231,818)	(40,705)	(59,528)	(332,051)
2025-12-31	**-**	**346,364**	**105,038**	**171,587**	**622,989**
Хуримтлагдсан элэгдэл					
2024-01-01	**(479)**	**(105,236)**	**(102,949)**	**(169,736)**	**(378,400)**
Тухайн жилийн өөрчлөлт	-	(33,123)	(10,324)	(26,636)	(70,083)
2024-12-31	**(479)**	**(138,359)**	**(113,273)**	**(196,372)**	**(448,483)**
Тухайн жилийн өөрчлөлт	479	24,836	30,152	28,096	83,563
2025-12-31	**-**	**(113,523)**	**(83,121)**	**(168,276)**	**(364,920)**
Дансны үнэ					
2024-12-31	**-**	**193,459**	**32,093**	**34,743**	**260,295**
2025-12-31	**-**	**232,841**	**21,917**	**3,311**	**258,069**

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

8. Биет бус хөрөнгө

Мянган төгрөгөөр	Программ хангамж	Виртуал хөрөнгө	Бусад хөрөнгө	Нийт
Өртөг				
2024 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	**118,645**	**88,417**	**130,319**	**337,381**
Нэмэгдсэн	-	5,814,842	2,129,017	7,973,859
Хасагдсан	-	(5,553,133)	(2,129,017)	(7,682,150)
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**118,645**	**350,126**	**130,319**	**599,090**
Нэмэгдсэн	-	17,397,305	-	17,397,305
Хасагдсан	-	(11,398,436)	-	(11,398,436)
2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**118,645**	**6,348,995**	**130,319**	**6,597,959**
Хуримтлагдсан элэгдэл				
2024 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	**(55,236)**	**-**	**(19,865)**	**(75,101)**
Тухайн жилийн өөрчлөлт	(12,425)	-	(10,800)	(23,225)
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**(67,661)**	**-**	**(30,665)**	**(98,326)**
Тухайн жилийн өөрчлөлт	(12,425)	-	(10,800)	(23,225)
2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**(80,086)**	**-**	**(41,465)**	**(121,551)**
Дансны цэвэр үнэ				
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**50,984**	**350,126**	**99,654**	**262,280**
2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**38,559**	**6,348,995**	**88,854**	**6,476,409**

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

9. Ашиглах эрхтэй хөрөнгө

Мянган төгрөгөөр	**Оффисын түрээс**	**Нийт**
2024 оны 1-р сарын 1-нээрх	**4,808,048**	**4,808,048**
Нэмэгдэл	4,827,659	4,827,659
Хасагдсан	-	-
2024 оны 12-р сарын 31-нээрх	**9,635,707**	**9,635,707**
Нэмэгдэл	898,941	898,941
Хасагдсан	(5,416,541)	(5,416,541)
2025 оны 12-р сарын 31-нээрх	**5,118,107**	**5,118,107**
Элэгдэл болон үнэ цэний бууралт		
2024 оны 1-р сарын 1-нээрх	**(4,047,790)**	**(4,047,790)**
Нэмэгдэл	(1,426,133)	(1,426,133)
Хасагдсан	-	-
2024 оны 12-р сарын 31-нээрх	**(5,473,923)**	**(5,473,923)**
Нэмэгдэл	(1,468,590)	(1,451,514)
Хасагдсан	2,662,618	2,662,618
2025 оны 12-р сарын 31-нээрх	**(4,279,895)**	**(4,262,819)**
Дансны үнэ 2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**838,212**	**838,212**

Ашиглах эрхтэй хөрөнгийн түрээсийн өр төлбөр:

Мянган төгрөгөөр	**2025-12-31**	**2024-12-31**
Богино хугацаат өр төлбөр	367,955	1,319,671
Урт хугацаат өр төлбөр	437,134	2,963,093

Оффисын түрээсийн гэрээний 2025 оны 11 сарын 06-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр охин компаниудад хуваарилагдах талбайг тус бүрд нь ногдуулан түрээслэхээр болсон тул өмнө хүлээн зөвшөөрсөн ашиглах эрхтэй хөрөнгө болон санхүүгийн түрээсийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрч оронд нь өөрт ногдох түрээсийн зардлаар ашиглах эрхтэй хөрөнгө болон санхүүгийн түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

10. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Мянган төгрөгөөр	**2025-12-31**	**2024-12-31**
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	35,551,843	37,721,322
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	6,192,544	6,288,140
Бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгдэх хөрөнгө оруулалт	2,424,409	2,603,343
Хоёрдогч өглөг	5,000,000	5,000,000
Урт хугацаат хөрөнгө оруулалтын дүн	**49,169,436**	**51,612,805**

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

10. Урт хугацаат хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл дараах байдалтай байна.

Мянган төгрөгөөр	**2025-12-31**	**2024-12-31**
Ард кредит ББСБ ХК	16,493,292	17,833,179
Ард Холдингс интернэшнл ХХК	305,000	305,000
Ард секюритиз ҮЦК ХХК	5,314,324	5,314,324
Ард менежмент ХХК	2,049,691	2,049,691
Ард даатгал ХК	8,317,761	9,147,354
Ард пропертиз ХХК	3,022,366	3,022,366
ХАСҮ сан	49,049	49,409
Нийт дүн	**35,551,843**	**37,721,322**

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл дараах байдалтай байна.

Мянган төгрөгөөр	**2025-12-31**	**2024-12-31**
Эхний үлдэгдэл	**6,288,140**	**7,998,595**
Нэмэгдсэн	-	4,734
Ашиг/(алдагдал)-ын ногдох хэсэг	-	-
БҮЦ-ийн өөрчлөлт	(95,596)	(1,572,721)
Бусад хөдөлгөөн	-	(142,468)
Эцсийн үлдэгдэл	**6,192,544**	**6,288,140**

Компанийн хараат компаниудын талаарх санхүүгийн мэдээлэл нь дараах байдалтай байна.

Нэр	**Үндсэн үйл ажиллагаа**	**Байгуулагдсан улс**	**Хувьцаа эзэмшлийн хувь** **2025**	**2024**
Монгол шуудан ХК	Хадгаламж зээлийн хоршоо	Монгол Улс	20.1%	20.1%

Компанийн хараат компаниудын талаарх санхүүгийн мэдээлэл нь дараах байдалтай байна.

Мянган төгрөгөөр	**2025-12-31**	**2024-12-31**
Нийт хөрөнгө	35,557,342	37,029,570
Нийт өр төлбөр	9,702,632	11,404,904
Цэвэр хөрөнгө	25,854,710	25,624,665
Хараат компанийн цэвэр хөрөнгөд эзлэх хувь (Компанийн хувь)	23.9%	24.5%

Мянган төгрөгөөр	**2025-12-31**	**2024-12-31**
Нийт орлого	25,423,476	24,395,514
Нийт ашиг/(алдагдал)	472,548	1,998,228

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

10. Урт хугацаат хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийдэгдэх хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл дараах байдалтай байна.

Мянган төгрөгөөр	**2025-12-31**	**2024-12-31**
Үндэсний хувьчлалын сан ХОС	40,901	48,011
Ард Актив ХЗХ	967,880	967,880
Тэнгэрлиг медиа групп ХК	280,855	308,683
Мост Финтек ХК	786,692	923,348
Өндөрхаан ХК	334,516	334,516
Хөвсгөл ХК	606	7,087
Хасбанк ХК	3,975	3,406
Анд Энерги ХК	1,608	938
Дархан нэхий ХК	2,561	2,039
Крипто Үндэстэн ХК	4,454	7,435
Нийт дүн	**2,424,049**	**2,603,343**

Хоёрдогч өглөг:

"Ард кредит ББСБ" ХК-ийн 2022 оны 4 сарын 30-ны өдрийн №04/22 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол, СЗХ-ны даргын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн №531 тоот "Хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татахыг зөвшөөрөх тухай" тушаалуудын дагуу 2022 оны 12 сарын 19-ний өдөр "Ард кредит ББСБ" ХК-д 5,000,000 мянган төгрөгийг 12% хүүтэй, 5 жилийн хугацаатай ба хугацааны эцэст хувьцаанд хөрвөх нөхцөлтэйгөөр хоёрдогч өглөгийн гэрээ байгуулсан байна.

11. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдлийг үндсэн валютаар илэрхийлбэл:

Мянган төгрөгөөр	**2025-12-31**	**2024-12-31**
Төгрөг	7,495	5,137
Ам доллар	86	65
Нийт дүн	**7,581**	**5,202**

12. Дансны болон бусад авлага

Мянган төгрөгөөр	**2025-12-31**	**2024-12-31**
Дансны авлага	1,837,985	2,754,871
Найдваргүй дансны авлагын хасагдуулаг	(231,685)	(231,685)
Цэвэр дансны авлага	**1,606,299**	**2,523,186**
Холбоотой талаас авах авлага	58,892,177	48,586,525
Ажиллагсдаас авах авлага	174,667	481,622
Хүүгийн авлага	202,355	247,568
Санхүүгийн хөрөнгийн дүн	**59,269,199**	**51,838,901**
Татварын авлага	149,548	142,570
Санхүүгийн бус хөрөнгийн дүн	**149,548**	**142,570**
Нийт дансны болон бусад авлагын дүн	**61,025,046**	**53,515,762**

ХУУДАС

13. Бараа материал

Мянган төгрөгөөр	**2025-12-31**	**2024-12-31**
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	85,467	111,593
Хангамжийн материал	-	201
Нийт бараа материал	**85,467**	**111,794**

14. Урьдчилж төлсөн тооцоо

Мянган төгрөгөөр	**2025-12-31**	**2024-12-31**
Хувьцааны урамшууллын тооцоо	787,695	1,118,776
Ажилчдын хуримтлал ТНД	55,033	33,229
Урьдчилж төлсөн даатгал	8,400	6,668
Урьдчилж төлсөн тооцоо – Ардын альфа	9,091	-
Бусад урьдчилгаа	663,026	708,827
Нийт урьдчилж төлсөн тооцоо	**1,523,245**	**1,867,500**

15. Бусад санхүүгийн хөрөнгө

Мянган төгрөгөөр	**2025-12-31**	**2024-12-31**
Ашиг алдагдлаар илэрхийлэгдэх хөрөнгө оруулалт	277,424	248,724
Нийт урьдчилж төлсөн тооцоо	**277,424**	**248,724**

16. Дансны болон бусад өр төлбөр

Мянган төгрөгөөр	**2025-12-31**	**2024-12-31**
Дансны өглөг	32,063,954	25,425,113
Холбоотой талуудад төлөх өр төлбөр	7,122,300	5,713,117
Хүүгийн өглөг	42,926	184,758
Ногдол ашгийн өглөг	-	1,065
Санхүүгийн өр төлбөр	**39,229,180**	**31,324,053**
Татварын өглөг	93,522	1,516,835
Цалингийн өглөг	-	18,383
НДШ-ийн өр	11,317	47,785
Санхүүгийн бус өр төлбөр	**104,839**	**1,583,003**
Дансны болон бусад өглөгийн дүн	**39,334,019**	**32,120,066**

17. Богино болон урт хугацаат зээл

Мянган төгрөгөөр	Богино хугацаат		Урт хугацаат	
	2025-12-31	2024-12-31	2025-12-31	2024-12-31
Холбоотой талуудаас авсан зээллэг	4,886,112	4,771,774	-	-
Банкны зээллэг	1,138,131	1,094,480	9,611,853	7,758,183
Зээлийн дүн	**6,024,244**	**5,866,254**	**9,611,853**	**7,758,183**

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

17. Богино болон урт хугацаат зээл (үргэлжлэл)

Зээлийн мэдээллийг дэлгэрэнгүй харуулбал:

Мянган төгрөгөөр	Валют	Хүүгийн түвшин	Эхэлсэн огноо	Дуусах огноо	2025-12-31	2024-12-31
Худалдаа хөгжлийн банк	Ам.доллар	13.2%	2023.06.23	2028.06.23	9,105,050	9,947,143
Михайл Зелдович	Төгрөг	18.0%	2023.06.27	2025.08.27	420,000	600,000
Ард Актив ХЗХ	Төгрөг	22.0%	2021.08.31	2026.08.30	2,123,868	2,500,000
Богд банк	Төгрөг	22.8%			1,450,000	-
Ард Кредит ББСБ ХК	Төгрөг	12.0%	2025.06.26	2027.06.26	2,102,244	1,540,039
Ард Лизинг ХХК	Төгрөг	24.0%	2025.09.30	2026.09.30	240,000	-
Хасбанк ХК	Төгрөг	21.6%	2025.04.01	2030.03.31	194,935	-

18. Урьдчилж орсон орлого

Мянган төгрөгөөр	2025-12-31	2024-12-31
Эхний үлдэгдэл	7,525,707	19,407,578
Нэмэгдсэн	932,657	623,321
Хасагдсан (орлогоор хүлээн зөвшөөрсөн)	(1,061,376)	(12,505,192)
Урьдчилж орсон орлогын дүн	**7,396,988**	**7,525,707**

19. Богино хугацаат бондын өр төлбөр

Мянган төгрөгөөр	2025-12-31	2024-12-31
Богино хугацаат хаалттай бондын өр төлбөр		
Гацуурт ХХК	370,000	370,000
Ард Пропертиз ХХК	3,150,000	-
Урьдчилж орсон орлогын дүн	**3,520,000**	**370,000**

Компани нь Гацуурт ХХК-ийн 370,000 мянган төгрөгийн хаалттай бонд эзэмшиж байгаа бөгөөд үүн дээр 2025 онд Ард пропертиз ХХК-д үл хөдлөх хөрөнгө худалдан авахад зориулж 3,150,000 мянган төгрөгийн хаалттай бонд гаргасан.

20. Хойшлогдсон татварын өр төлбөр

Мянган төгрөгөөр	2025	2024
Эхний үлдэгдэл	**1,207,756**	**3,413,193**
Нягтлан бодох бүртгэлийн алдааны залруулга	(52,447)	(86,074)
Ашиг, алдагдлыг бууруулсан	(33,351)	(414,749)
Бусад дэлгэрэнгүй орлогыг бууруулсан	(754,003)	(1,704,614)
Нийт хойшлогдсон татварын дүн	**367,955**	**1,207,756**

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

21. Бусад нөөц өр төлбөр

Мянган төгрөгөөр	**2025**	**2024**
Эхний үлдэгдэл	**-**	**-**
Нэмэгдсэн	1,057,971	-
Бусад нөөц өр төлбөрийн дүн	**1,057,971**	**-**

Хойшлогдсон татварын өр төлбөрийн залруулга хийсэн ба тухайн тайлант хугацаанд тайлагнаагүй тул бусад нөөц өр төлбөр буюу болзошгүй өр төлбөрөөр бүртгэв.

22. Эздийн өмч

22.1. Хувийн өмч

Хувьцаат капитал /дүрмийн сан/

Хувьцааны тоо өөрөөр заагаагүй бол	Энгийн хувьцаа	
	2025	**2024**
Зөвшөөрөгдсөн хувьцаа		
Нэг бүр нь 1,000 төгрөгийн үнэтэй 28,614,263 ширхэг энгийн хувьцаа	**28,614,263**	**28,614,263**
Нэмж төлөгдсөн капитал	**492,181**	**2,927,696**

Компани нь тогтмол орлогын эрхгүй энгийн хувьцааны нэг л ангилалтай.

22.2. Эздийн өмчийн бусад хэсэг

Мянган төгрөгөөр	**2025.12.31**	**2024.12.31**
Дахин үнэлгээний нэмэгдэл	3,789,108	1,803,519
Эздийн өмчийн бусад хэсэг	13,799	13,799
Бусад өмчийн нийт дүн	**3,802,907**	**1,817,318**

22.3. Хуримтлагдсан ашиг

Үйл ажиллагаа эхэлсэн үеэс нэмэгдсэн капитал. Энэ нь тухайн тайлангийн хугацаанд олсон цэвэр ашгийн хэмжээгээр нэмэгдэнэ.

23. Орлого

Мянган төгрөгөөр	**2025.12.31**	**2024.12.31**
Охин компаниас олсон менежментийн үйлчилгээний орлого	1,441,748	1,000,867
Бусад холбоотой талаас олсон менежментийн үйлчилгээний орлого	76,268	1,850,339
Холбоотой талд үзүүлсэн үйлчилгээ үзүүлэх гэрээний орлого	2,078,636	662,074
Бусад өмчийн нийт дүн	**3,596,651**	**3,513,280**

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

24. Ногдол ашгийн орлого

Мянган төгрөгөөр	**2025.12.31**	**2024.12.31**
Охин компанийн ногдол ашгийн орлого		
Ард даатгал ХК	-	341,337
Ард кредит ББСБ ХК	-	476,064
Бусад холбоотой талын ногдол ашгийн орлого		
Хасбанк ХК	111	54,514
Монгол шуудан ХК	7,960	-
Нийт ногдол ашгийн орлого	**8,071**	**871,915**

25. Борлуулалт, маркетингийн зардал

Мянган төгрөгөөр	**2025**	**2024**
Зар сурталчилгааны зардал	150	13,082
Маркетингийн зардал	128,004	672,669
Нийт борлуулалт, маркетингийн зардал	**128,154**	**685,751**

26. Ерөнхий ба удирдлагын зардал

Мянган төгрөгөөр	**2025**	**2024**
Цалин	957,209	1,547,425
Нийгмийн даатгалын шимтгэл	118,462	192,488
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	1,218,446	1,448,002
Элэгдэл, хорогдлын зардал	1,025,126	1,375,050
Түрээсийн зардал	70,354	70,354
Шуудан холбооны зардал	77,728	103,439
Ашиглалтын зардал	74,668	57,186
Бичиг хэргийн зардал	4,445	7,197
Хангамжийн материал	180,509	131,170
Албан томилолтын зардал	456,236	78,666
Урсгал засварын зардал	25,968	63,938
Банкны үйлчилгээний шимтгэл	1,534	1,453
Даатгалын зардал	16,724	16,438
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	380	537
Шатахуун, сэлбэг хэрэгслийн зардал	22,275	48,605
Сургалтын зардал	3,767	7,757
Бусад зардал	880,758	252,906
Хувьцааны урамшууллын зардал	-	4,000
Хурал, хүлээн авалтын зардал	70,390	110,604
Нийт ерөнхий удирдлагын зардлын дүн	**5,204,979**	**5,517,215**

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

27. Бусад орлого, зардал

Мянган төгрөгөөр	**2025.12.31**	**2024.12.31**
Зардлын хуваарилалт	56,000	43,144
Бусад орлого	160,838	127,501
Бусад зардал		
Алданги, торгуулийн зардал	(63,053)	(21,943)
Найдваргүй авлагын зардал	-	(326,154)
Баяр ёслолын арга хэмжээний зардал	(281,093)	(163,678)
Хандивын зардал	(30,000)	(4,000)
Урамшууллын зардал	(1,600)	(6,100)
Бусад орлого, зардлын цэвэр дүн	**(158,908)**	**(351,230)**

28. Санхүүгийн зардал

Санхүүгийн зардал нь дараахаас бүрдэж байна:

Мянган төгрөгөөр	**2025**	**2024**
Хорогдуулсан өртгөөр бүртгэх зээлийн хүүгийн зардал		
- Холбоотой талаас авсан зээлийн хүүгийн зардал	2,387,567	1,430,202
- Холбоогүй талаас авсан зээлийн хүүгийн зардал	1,184,495	2,220,268
Санхүүгийн түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал	497,248	328,029
Капиталжуулсан хүүгийн зардал	26,841	20,717

Санхүүгийн орлого нь дараахаас бүрдэж байна:

Мянган төгрөгөөр	**2025**	**2024**
Мөнгө, түүнтэй адилтгах орлогоос олсон хүүгийн орлого	177	352
Хоёрдогч хүүгийн орлого	600,000	755,414
Холбоотой талуудад олгосон зээлийн хүүгийн орлого	-	138,154
Санхүүгийн орлого, зардлын цэвэр дүн	**(3,495,974)**	**(3,105,296)**

29. Гадаад валютын ханшийн зөрүүний олз/(гарз)

Мянган төгрөгөөр	**2025**	**2024**
Гадаад валютын ханшийн зөрүүний хэрэгжсэн олз/(гарз)	(676)	67,783
Гадаад валютын ханшийн зөрүүний хэрэгжээгүй олз/(гарз)	(405,881)	(134,918)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/(гарз)-ын дүн	**(406,557)**	**(67,135)**

30. Виртуал хөрөнгийн үнэлгээнээс үүссэн олз/(гарз)

Мянган төгрөгөөр	**2025**	**2024**
Виртуал хөрөнгийн үнэлгээний олз/(гарз)	6,306,013	(412,132)
Виртуал хөрөнгө данснаас хассаны олз/(гарз)	767	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/(гарз)-ын дүн	**6,306,780**	**(412,132)**

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

31. Бусад олз/(гарз)

Мянган төгрөгөөр	2025	2024
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	(295)	-
Хөрөнгө оруулалт данснаас хассаны олз (гарз)	159,577	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз	(13,880)	
Ашиг алдагдлаарх ХО-ын хэрэгжээгүй олз (гарз)	100	
Нийт бусад олз/(гарз)-ын дүн	**145,502**	**(11,751)**

32. Орлогын албан татварын зардал/(нөхөлт)

Ашиг, алдагдалд тайлагнагдсан орлогын албан татвар нь дараах хэсгээс бүрдэнэ:

Мянган төгрөгөөр	2025	2024
Тайлант жилийн орлогын албан татварын зардал	-	15,201
Тусгайлсан хувь хэмжээгээр тооцох орлогын албан татвар	11,811	143,622
Хойшлогдсон татвар	(33,351)	(414,749)
Нийт	**(21,540)**	**(255,926)**

33. Холбоотой талууд

33.1 Хяналтын харилцаа

2025 оны 12 сарын 31-нээрх компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна.

№	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо	Хувь
1	И Ай Ти	2,775,406	10%
2	Ардын тэтгэврийн данс ХХК	2,517,778	9%
3	Bruno Eduard	2,109,997	7%
4	Авир Сүхдорж	1,944,990	7%
5	Чулуун Ганхуяг	1,590,466	6%
6	Ард Венчурс ХХК	1,429,244	5%
7	Галням Уянга	1,389,754	5%
8	DAX (ARDT эзэмшигчид)	900,000	3%
9	Ард Лизинг ХХК	680,976	2%
10	Ард Кредит ББСБ ХК	525,489	2%
11	Сэдбазар Гэрэлтуяа	455,935	2%
12	RONOC LIMITED	443,816	2%
13	Ард Секюритиз ҮЦК ХХК	400,988	1%
14	Сүхдорж Оргил	390,937	1%
15	Ганхуяг Бат-Эрдэнэ	351,265	1%
Топ 15 хувьцаа эзэмшигчид		**17,907,044**	**63%**
Бусад хувьцаа эзэмшигчид		**10,707,219**	**37%**
Нийт зарласан хувьцаа		**28,614,263**	**100%**

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

33.2 Охин компанитай хийсэн ажил гүйлгээ

Тайлант хугацааны охин компаниудад Ард Актив ХЗХ, Ард Даатгал ХК, Ард Кредит ББСБ ХК, Ард Лизинг ХХК, Ард Менежмент ХХК, Ард Пропертиз ХХК, Ард Секюритиз ҮЦК ХХК, Ард Суппорт ХХК, Ард Финтек Солюшн ХХК, Ардын тэтгэврийн данс ХХК, Тэнгэр системс ХХК зэрэг компаниуд багтана.

Мянган төгрөгөөр	**2025-12-31**	**2024-12-31**
Хөрөнгө оруулалт	-	4,247,076
Үйлчилгээ үзүүлсэн	1,112,128	1,000,867
Хүүгийн орлогын хуримтлал	612,709	893,568
Зээлийн эргэн төлөлт	37,344	(5,125,431)
Хүүгийн зардлын хуримтлал	2,040,814	1,430,202
Бодит үнэ цэний тохируулга	1,233,302	1,545,309

33.3 Бусад холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Тайлант хугацааны бусад холбоотой компаниудад Айдакс ХХК, Анрид ХХК, Аравт Бит, Ард Бит ХХК, Гэр Интерьер Дизайн ХХК, Ард инвестмент ХХК, Грэйпсити Монгол ХХК, Икс И Партнерс ХХК, Крипто Үндэстэн ХК, Монгол Дифай ХХК, Монгол HD TV, Монгол шуудан ХК, Мост Финтек ХХК, Номын Хишиг ХХК, Нэкст Сошиал Платформ ХХК, Ори Медиа ХХК, Ори Студиос ХХК, Про Медиа Нэтворк ХХК, Скоп Аллианс ХХК, ТТДС ХХК, Тэнгэрлиг Медиа Групп, Улаанбаатар Үнэт цаасны бирж, Эй Ай Дайверс Солюшн ХХК, Акела Секюрити ХХК, Өндөрхаан ХХК, Ард Венчурс ХХК, МПЕРС ХХК, МНЭТ ХХК, Ардэкс ХХК зэрэг компаниуд байна.

Мянган төгрөгөөр	**2025 он**	**2024 он**
Үйлчилгээ үзүүлсэн	156,271	1,850,339
Хөрөнгө оруулалт	4,095,647	3,646,246
Бодит Үнэ цэний тохируулга	250,351	6,308,977

33.4 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний үлдэгдэл

Мянган төгрөгөөр	**2025-12-31**	**2024-12-31**
Авлага		
- Дансны авлага		
Акела секюритиз ХХК	1,260,872	705,513
Ард даатгал ХК	1,667	-
Ард Актив ХЗХ	19,813	-
Ард Бит ХХК	12,251,583	4,116,031
Ард Венчурс ХХК	6,609,289	1,845,163
Ард Кредит ББСБ ХК	1,667	-
Ард Лизинг ХХК	890,826	-
Ард Менежмент ХХК	192,887	-
Ард Пропертиз ХХК	54,118	-
Ард Суппорт ХХК	289,963	-
Ард Финтек Солюшн ХХК	138,447	-

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

Ардын тэтгэврийн данс ХХК	550	-
Ард Экс ХХК	1,264,246	1,257,137
И Ай Ти ХХК	17,827	-
МПЕРС ХХК	200,000	200,000
Тэнгэр Системс ХХК	1,864,236	1,607,675
- Хувьцааны авлага		
Өндөрхаан ХК	25,010,000	20,610,000
Хөвсгөл ХХК	-	10,933,304
- Бусад авлага		
Айдакс ХХК	200,000	231,125
Анрид ХХК	207,804	207,804
Аравт Бит ХХК	1,028	1,028
Ард Бит ХХК	1,074,665	1,074,665
Грэйпсити Монголиа ХХК	2,477,893	200,000
Икс И Партнерс ХХК	1,727	1,727
Крипто Үндэстэн ХК	284,260	607,793
Монгол Дифай	235,291	235,291
Монгол HD TV	117,269	117,269
Монгол Шуудан ХК	18,297	11,684
Мост Финтек ХХК	207,804	207,804
Нэкст Сошиал Платформ Провайдер ХХК	75,723	75,723
Ори Медиа ХХК	117,267	117,269
Ори Студиос ХХК	909,295	539,007
Про Медиа Нетворк ХХК	1,148,922	1,172,766
Скоп Аллианс ХХК	125,084	125,084
ТТДС ХХК	702,519	702,519
Тэнгэрлиг Медиа Групп ХХК	298,365	288,365
Улаанбаатар үнэт цаасны бирж	241,386	1,018,341
Ард инвестмент ХХК	1,482,580	612,333
Эй Ай Дайверс Солюшн ХХК	117,269	117,269
Нийт дүн	**60,112,439**	**48,939,689**

Өглөг		
- Дансны өглөг		
Ард секюритиз ХХК	39,684	35,180
Ардын тэтгэврийн данс ХХК	2,995,856	-
Хөвсгөл ХХК	2,176,659	2,486,563
Ард кредит ББСБ ХК	4,742,978	1,373,353
Ард пропертиз ХХК	3,841,073	4,427,132
Ард Финтек Солюшн ХХК	787,905	1,296,079
МНЭТ ХХК	1,459,525	1,962,812
- Бусад өр төлбөр		
Акела секюритиз ХХК	1,640,285	1,560,294
Мост Финтек ХХК	825	76,770
Өндөрхаан ХК	3,284,950	3,195,081
- Хувьцааны өглөг		
Айдакс ХХК	200,000	-

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

Акела секюритиз ХХК	100,000	-
Анрид ХХК	200,000	-
Ард Бит ХХК	200,000	-
Ард Венчурс ХХК	200,000	-
Ард Кредит ББСБ	200,000	-
Ард пропертиз ХХК	200,000	-
Ард Секюритиз ҮЦК	200,000	-
Ард Суппорт ХХК	200,000	-
Ардын тэтгэврийн данс ХХК	3,281,843	-
ГРЭЙПСИТИ МОНГОЛ ХХК	200,000	-
И Ай Ти ХХК	200,000	-
Крипто Үндэстэн ХК (BUN-CNF)	200,000	-
Монгол Дифай	200,000	-
Монгол HD TV	100,000	-
Мост Финтек ХХК	200,000	-
МПЕРС ХХК	200,000	-
Ори Медиа ХХК	100,000	-
Ори Студиос ХХК	200,000	-
ПРО МЕДИА НЕТВОРК ХХК	100,000	-
Скоп Аллианс ХХК	100,000	-
ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК	200,000	-
Тэнгэр системс ХХК	200,000	-
Хөвсгөл ХХК	100,000	-
Эй Ай Дайверс Солюшн ХХК	100,000	-
Эм И Си Партнерс ХХК	100,000	-
Нийт Дүн	**28,451,583**	**16,413,264**

34. Санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл

Хүлээн зөвшөөрөх шалгуур, орлого зарлагыг хүлээн зөвшөөрөх үндэслэл, санхүүгийн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн хэрэглүүрийн ангиллын талаар хэрэглэж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, арга зэргийг тодруулга 4.8-д дэлгэрэнгүй харуулсан болно. Компани нь санхүүгийн хэрэглүүрийн идэвхтэй арилжаанд оролцдоггүй. Компанийн өртөж болох томоохон санхүүгийн эрсдэл нь доорх байдалтай байна.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

34. Санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл (үргэлжлэл)

34.1 Зах зээлийн эрсдэл

Компани санхүүгийн хэрэглүүрүүдийг хэрэглэх явцад зах зээлийн эрсдэл, үүнд үндсэн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүдэн гарах гадаад валют, хүүгийн түвшин болон бусад үнийн эрсдэлтэй тулгардаг байна.

34.2 Зээлжих эрсдэл

Зээлжих эрсдэл нь Компанид санхүүгийн эрсдэл үүссэний улмаас гэрээний үүргээ гүйцэтгэж чадахгүй болох эрсдэлийг харуулдаг. Компанийн хувьд энэхүү эрсдэлийн нөлөөлөл нь дансны авлага, хугацаат хадгаламж, гэрээний хугацаа дуустал эзэмших хөрөнгө оруулалт, өрийн хэрэглүүр гэх мэт өөр өөр санхүүгийн хэрэгслээс үүсдэг. Дараах санхүүгийн хэрэглүүрийн дансны үнээр хамгийн их зээлжих эрсдэлийг харуулав:

Мянган төгрөгөөр	**2025.12.31**	**2024.12.31**
Санхүүгийн хөрөнгө дансны үнээр		
Өмчийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалт	49,169,436	51,612,805
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	-	4,095,647
Бусад санхүүгийн хөрөнгө	277,424	248,724
Дансны болон бусад авлага	61,025,046	51,981,471
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,581	5,201

Дансны авлага

Компанийн дансны авлага нь томоохон санхүүгийн бүрэлдэхүүн бүхий зүйлсийг агуулаагүй тул тэдгээрийн хүлээгдэж буй зээлийн алдагдлыг (найдваргүй авлагын зардал) тооцохдоо СТОУС 9-ийн дагуу хялбаршуулсан загварыг ашигладаг.

Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихдээ дансны авлагын цуглуулагдах хугацаанд үндэслэн үнэлдэг. Тэдгээр авлагыг хугацаа хэтэрсэн хоногоор нь бүлэглэдэг.

Найдваргүй авлагын нөөцийг байгуулахдаа нөөцийн аргыг ашигладаг. Авлагыг ТУЗ-ийн шийдвэрийн дагуу данснаас хасдаг.

Мянган төгрөгөөр	Дүн
2024 оны 01 сарын 01-ний найдваргүй авлагын нөөцийн үлдэгдэл	**(55,188)**
Тайлант хугацаанд нэмж байгуулсан нөөц	(231,685)
Тайлант хугацаанд ашиглаагүй, буцаасан нөөц	55,198
2024 оны 12 сарын 31-ний найдваргүй авлагын нөөцийн үлдэгдэл	**(231,685)**
Тайлант хугацаанд нэмж байгуулсан нөөц	-
Тайлант хугацаанд ашиглаагүй, буцаасан нөөц	-
2025 оны 12 сарын 31-ний найдваргүй авлагын нөөцийн үлдэгдэл	

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

34. Санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл (үргэлжлэл)

34.3 Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь компани хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байх эрсдэл юм. Компанийн бодлого нь үйл ажиллагааны болон зээлийн үйлчилгээтэй холбоотой төлбөрийг барагдуулахад хангалттай мөнгөн хөрөнгө болон түргэн борлогдох хөрөнгөтэй байх оновчтой хөрвөх чадварын удирдлагын бодлого хэрэгжүүлэх юм.

Дараах хүснэгтээр гэрээнд заасан эргэн төлөгдөх хугацаатай үүсмэл бус санхүүгийн өр төлбөрүүдийг төлөх Компанийн үлдсэн гэрээний хугацааг харуулав. Компани төлөх шаардлагатай эхний өдөр санхүүгийн өр төлбөрийн дискаунтчилаагүй мөнгөн гүйлгээнд үндэслэн уг хүснэгтийг гаргасан.

2025 оны 12 сарын 31	Богино хугацаат		Урт хугацаат	
	6 сараас бага	6 сараас 12 сар	1-5 жил	5-с дээш жил
Зээл	420,000	3,813,868	11,402,229	-
Хаалттай бондын өр	-	3,520,000	-	-
Санхүүгийн түрээсийн өглөг	-	392,493	437,134	-
Дансны болон бусад өглөг	39,202,900	-	-	-
Нийт дүн	**39,622,900**	**7,726,361**	**11,839,363**	-

2024 оны 12 сарын 31	Богино хугацаат		Урт хугацаат	
	6 сараас бага	6 сараас 12 сар	1-5 жил	5-с дээш жил
Зээл	4,376,496	2,475,930	12,193,298	-
Хаалттай бондын өр	370,000	-	-	-
Санхүүгийн түрээсийн өглөг	608,298	-	-	-
Дансны болон бусад өглөг	20,251,788			
Нийт дүн	25,606,582	**2,475,930**	**12,193,298**	-

35. Бодит үнэ цэний хэмжилт

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн тайланд бодит үнэ цэний шатлалаар гурван түвшинд ангилна. Эдгээр гурван ангиллыг бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан орцуудын ач холбогдолд үндэслэнэ.

Түвшин 1: Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан тодорхойлно.

Түвшин 2: Хөрөнгө болон өр төлбөрийн хувьд боломжит өгөгдлийг ашиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) бодит үнэ цэнийг тодорхойлох аргачлалыг 2-р түвшинд хэрэгжүүлнэ;

Түвшин 3: Зах зээлийн ашиглаж болох өгөгдөлд тулгуурлахгүйгээр (ашиглагдахгүй өгөгдөл) бодит үнэ цэнийг тодорхойлно. Удирдлага нь санхүүгийн хэрэглүүрийг ангилахдаа бодит үнэ цэний түвшнийг ашигладаг.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

35. Бодит үнэ цэний хэмжилт (үргэлжлэл)

Дараах хүснэгтээр бодит үнэ цэнийг хэмжсэн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийн шатлалыг түвшин тус бүрээр харуулав.

2025 оны 12 сарын 31	**Түвшин 1**	**Түвшин 2**	**Түвшин 3**	**Нийт**
Санхүүгийн хөрөнгө				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	-	7,581	-	7,581
Дансны болон бусад авлага	-	61,025,046	-	61,025,046
Урт хугацаат санхүүгийн хөрөнгө	32,459,766	11,708,670	5,000,000	49,168,436
Бусад санхүүгийн хөрөнгө	-	277,424	-	277,424
Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа эргэлтийн бус хөрөнгө	-	-	-	-
Санхүүгийн хөрөнгийн дүн	**32,459,766**	**73,018,721**	**5,000,000**	**110,478,487**
Санхүүгийн өр төлбөр				
Хаалттай бондын өр төлбөр	-	3,520,000	-	**3,520,000**
Зээл	-	15,636,096	-	**15,636,096**
Санхүүгийн түрээсийн өглөг	-	829,627	-	**829,627**
Дансны болон бусад өр төлбөр	-	40,391,990	-	**40,391,990**
	-	**60,377,713**	**-**	**60,377,713**
Цэвэр бодит үнэ цэн	**32,459,766**	**12,641,008**	**5,000,000**	**50,100,774**

2024 оны 12 сарын 31	**Түвшин 1**	**Түвшин 2**	**Түвшин 3**	**Нийт**
Санхүүгийн хөрөнгө				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	-	5,202	-	5,202
Дансны болон бусад авлага	-	51,981,471	-	51,981,471
Урт хугацаат санхүүгийн хөрөнгө	34,904,136	11,708,669	5,000,000	51,612,805
Бусад санхүүгийн хөрөнгө	-	248,724	-	248,724
Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа эргэлтийн бус хөрөнгө	-	-	4,095,647	4,095,647
Санхүүгийн хөрөнгийн дүн	**34,904,136**	**63,944,066**	**9,095,647**	**107,943,849**
Санхүүгийн өр төлбөр				
Хаалттай бондын өр төлбөр	-	370,000	-	**370,000**
Зээл	-	14,718,916	-	**14,718,916**
Санхүүгийн түрээсийн өглөг	-	1,319,671	-	**1,319,671**
Дансны болон бусад өр төлбөр	-	31,324,053	-	**31,324,053**
Санхүүгийн өр төлбөрийн дүн	**-**	**47,732,640**	**-**	**47,732,640**
Цэвэр бодит үнэ цэн	**34,904,136**	**16,211,426**	**9,095,647**	**56,115,562**

Түвшин 2 болон 3-т ангилагдсан санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хэмжихдээ дараах үнэлгээний техникийг ашигладаг. Компани нь өөрсдийн хаалттай охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг тогтоож, санхүүгийн тайландаа толилуулахдаа Үнэлгээний олон улсын стандартын дагуу авч үзвэл Хөрөнгөд суурилсан хандлагаар тодорхойлсон.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

35. Бодит үнэ цэний хэмжилт (үргэлжлэл)

2025 оны 12 сарын 31	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт
Үндсэн хөрөнгө:		258,068		258,068
Биет бус хөрөнгө:				
Виртуал хөрөнгө	-	6,348,995	-	6,348,995
Бусад хөрөнгө	-	127,414	-	127,414

2024 оны 12 сарын 31	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт
Үндсэн хөрөнгө:	-	260,295	-	260,295
Биет бус хөрөнгө:				
Виртуал хөрөнгө	-	350,126	-	350,126
Бусад хөрөнгө	-	150,638	-	150,638

Үндсэн хөрөнгийг тайлангийн өдрөөр дахин үнэлээгүй бөгөөд анхны өртгөөр тусдаа санхүүгийн тайланд толилуулагдсан.Удирдлага нь тайлангийн өдөр болон худалдан авах өдрийн байдлаарх бодит үнэ цэнд материаллаг өөрчлөлт гараагүй гэж үзсэн.

36. Капиталын удирдлагын бодлого, журам

Компанийн капиталын удирдлагын бодлогын зорилго нь:

- Компани цаашид үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадавхыг хангах,
- Тухайн бүтээгдэхүүн үйлчилгээний холбогдох эрсдэлийн түвшнийг үндэслэн тэдгээрийн үнийг оновчтой тогтоох замаар хувьцаа эзэмшигчдэд зохистой өгөөжийг хүртээх,
- Компанийн зорилго нь капитал, санхүүжилтийн харьцааг зохистой түвшинд барих.

Санхүүгийн хараат байдлаас зайлсхийх үр ашигтай санхүүгийн бүтцийг бий болгохын тулд удирдлага Компани нь капиталын шаардлагыг үнэлнэ. Компани нь капиталын бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, хөрөнгийн эрсдэлийн шинж чанарыг харгалзан тохируулга хийдэг. Капиталын бүтцийг бий болгож, тохируулахын тулд хувьцааг халааслах, эсвэл өр төлбөрөө бууруулахаар хөрөнгө борлуулах зэрэг арга хэмжээ авахыг төлөвлөдөг.

Компанийн тайлант хугацааны капиталын дүнг доор хураангуйлан харуулав:

Мянган төгрөгөөр	2025.12.31	2024.12.31
Нийт эздийн өмч	51,518,232	54,621,352
Хасах: мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	(7,581)	(5,202)
Капитал	**51,510,651**	**54,616,150**
Нийт эздийн өмч	**51,518,232**	**54,621,352**
Нэмэх: зээл	15,636,096	14,718,917
Нэмэх: Хаалттай бонд	3,520,000	370,000
Нэмэх: Түрээсийн өр төлбөр	829,627	4,282,764
Бүх санхүүжилт	**71,503,955**	**73,993,033**
Капитал, санхүүжилтийн харьцаа	**72%**	**74%**

Хаалттай хувьцаат компанид оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэн буурснаас шалтгаалж цэвэр хөрөнгийн хэмжээнд ихээхэн нөлөөлсөн тул капитал, санхүүжилтийн харьцаа буурсан үзүүлэлттэй байна.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

37. Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага

Бизнесийн хэвийн явцад компани нь түүний эсрэг нэхэмжлэл хүлээн авч болно. Компанийн удирдлага өөрсдийн хийсэн тооцоолол дээр үндэслэн нэхэмжлэлүүдээс үүдэлтэйгээр эдгээр санхүүгийн тайланд тусгасан өр төлбөрийн нөөцийг давах хэмжээний материаллаг алдагдал үүсэхгүй гэж дүгнэж байна.

38. Тайлагналын өдрийн дараах үйл явдал

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудад нөлөө үзүүлэх өөр бусад үйл явдал тайлант хугацаа дуусгавар болсон өдрөөс хойш санхүүгийн тайланг хэвлэн нийтлэхийг зөвшөөрсөн өдрийг хүртэлх хугацаанд гараагүй гэж үзэж байна.

39. Тайлангийн орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Монгол, Англи хэл дээр бэлтгэсэн бөгөөд тэдгээрийн хооронд ялгаа, зөрчилдөх зүйл гарвал Англи хэл дээрх хувийг баримтална.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС